



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 397

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.4, 6.6 дахь заалт, 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухааны академийн харьяа Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй нийт 5,334,124.00 (таван сая гурван зуун гучин дөрвөн мянга нэг зуун хорин дөрвөн) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Шинжлэх ухааны академийн харьяа Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн захирал Д.Баттогтоход дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг хууль тогтоомж, журмын дагуу Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Акталж, данснаас хассан сэлбэгээр худалдсан автомашины улсын дугаарыг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

000608

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 0 дүгээр сарын 06 ны өдрийн
39 дугаар тогтоолын хавсралт

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ХАРЬАА ХҮРЭЭЛЭНГҮҮДИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	Тоёота чейзер, 61-22 УБЦ, арал GX1000078027/	1999	170791	7,235,400.00	500,000.00	500,000.00
2	УАЗ Фургон машин, 73-57 УБЭ, арал Y0022646	2000	366605	4,950,000.00	-	500,000.00
	НИЙТ ДҮН			12,185,400.00	500,000.00	1,000,000.00
				(Арван хоёр сая нэг зуун наян таван мянга дөрвөн зуу)	(таван зуун мянга)	(нэг сая)